



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2016 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Хорт хавдрын зарим тусламж, үйлчилгээний зардлын
эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх
төлбөрийн хэмжээг батлах тухай

Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.1.10, 11.2 даахь хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн Здугаар зүйл, Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн "Түр орлон гүйцэтгүүлэх тухай" 04 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Хорт хавдрын химиин өдрийн эмчилгээний зардлын эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээг тохиолдол бүрт 450 000 /дөрвөн зуун тавин мянга/ төгрөгөөр, хорт хавдрын туяаны эмчилгээний зардлын нэг өдрийн төлбөрийн хэмжээг 66 000 /жаран зургаан мянга/ төгрөгөөр, хорт хавдрын хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийн хэмжээг тохиолдол бүрт 300 000 /гурван зуун мянга/ төгрөгөөр тус тус тогтоосугай.

Хоёр. Энэ тогтоол гарсантай холбогдуулан хорт хавдрын химиин болон туяаны өдрийн эмчилгээ, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн байгууллагатай даатгалын гэрээ байгуулан, даатгуулагчдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг гүйцэтгэлээр тооцон, 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нөхөн олгож ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Мэндбаяр/-т зөвшөөрсүгэй.

Гурав. Тогтоолыг хэрэгжилтийг зохион байгуулах, холбогдох програм хангамжид өөрчлөлт оруулан ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/, Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Мэндбаяр/, эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал, ерөнхий эмч наарт тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /М.Саранчимэг/-д даалгасугай.

ДАРГА  С.ЭРДЭНЭ